

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/59/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www. Shinjlenmagadlahui ezsh.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089, 99023682 Цахим хаяг: <a href="mailto:Munkhbayarsh@audit.gov.mn">Munkhbayarsh@audit.gov.mn</a> Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 99036806 Цахим хаяг: <a href="mailto:Batsurenu@audit.gov.mn">Batsurenu@audit.gov.mn</a> Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 99377479 Цахим хаяг: <a href="mailto:Battsetsegs@audit.gov.mn">Battsetsegs@audit.gov.mn</a> Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК Утас: 99197346, 88114867 Цахим хаяг: <a href="mailto:Shinjlenmagadlahui.audit@gmail.com">Shinjlenmagadlahui.audit@gmail.com</a>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Contents

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	4
<b>Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг</b> .....	4
Дархан-Уул аймгийн Шарын гол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 65.3 хувийг цалин хөлс, 8.12 хувийг ажил олгогчоос төлөх Нийгмийн даатгалын шимтгэл, 1.4 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал тус тус эзэлж байна. ....	4
<b>3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл</b> .....	17
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	18
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	18
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	18
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	18
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....	19
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	19
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа, зөрчилтэй асуудал байхгүй. ....	19
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	19
<b>4.5.1 Завсрын аудитын талаар</b> .....	19
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал</b> .....	20
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	20
<b>5.1 Төлбөрийн акт</b> .....	20
Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно. ....	20
<b>5.2 Албан шаардлага</b> .....	20
<b>5.3 Зөвлөмж</b> .....	20
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	21

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ШАРЫН ГОЛ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА  
Б.БОЛОРЧИМЭГ ТАНАА**

2025.02.25 № 96  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Шарын гол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 65.3 хувийг цалин хөлс, 8.12 хувийг ажил олгогчоос төлөх Нийгмийн даатгалын шимтгэл, 1.4 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал тус тус эзэлж байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4525020194

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр тус иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын цалингийн зардал 192,113.3 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 2.1 дахин өссөн байна.

### **Бусад асуудал**

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 32 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилт 91.2 хувиар биелэлттэй байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР**



**Ш.МӨНХБАЯР**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

СТ-1А

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>I</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,963,799.00</b>	<b>8,638,759.00</b>
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	-	-
312	Банкинд байгаа	-	-
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>4,963,799.00</b>	<b>8,638,759.00</b>
354	<b>Хангамжийн материал</b>	<b>4,963,799.00</b>	<b>8,638,759.00</b>
3541	Бичиг хэргийн материал	854,000.00	1,358,300.00
3542	Аж ахуйн материал	3,860,299.00	7,030,959.00
3543	Сэлбэг хэрэгсэл	249,500.00	249,500.00
<b>II</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>35,615,988.62</b>	<b>41,757,853.93</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>35,615,988.62</b>	<b>41,757,853.93</b>
392	<b>Биет хөрөнгө</b>	<b>35,615,988.62</b>	<b>41,757,853.93</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	25,000,000.00	25,000,000.00
392	Хуримтлагдсан элэгдэл	(3,125,000.04)	(6,250,000.08)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	16,770,190.00	20,934,280.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(9,985,922.10)	(5,265,314.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,636,854.00	13,165,624.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,020,133.24)	(6,166,735.80)
39217	Ном	340,000.00	340,000.00
393	<b>Биет бус хөрөнгийн дүн</b>	<b>1,124,300.00</b>	<b>1,124,300.00</b>
39301	Програм хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,124,300.00)	(1,124,300.00)
<b>III</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>40,579,787.62</b>	<b>50,396,612.93</b>
<b>V</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>40,579,787.62</b>	<b>50,396,612.93</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>40,579,787.62</b>	<b>50,396,612.93</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	8,735,000.00	8,735,000.00
51101	Өмч: - төрийн	8,735,000.00	8,735,000.00
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>31,788,340.18</b>	<b>41,605,165.49</b>
5121	Өмнөх үеийн үр дүн	31,788,340.18	31,788,340.18
5122	Тайлант үеийн үр дүн	-	9,816,825.31
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	56,447.44	56,447.44
<b>VI</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>40,579,787.62</b>	<b>50,396,612.93</b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>145,810,300.00</b>	<b>311,697,080.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>2,999,880.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	<b>2,999,880.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	<b>2,999,880.00</b>
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	<b>2,999,880.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>145,810,300.00</b>	<b>308,697,200.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>9,500,000.00</b>	<b>12,000,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,500,000.00	<b>12,000,000.00</b>
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>136,310,300.00</b>	<b>296,697,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	136,310,300.00	<b>296,697,200.00</b>
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>147,480,832.83</b>	<b>300,206,977.01</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>147,480,832.83</b>	<b>300,206,977.01</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>133,316,095.90</b>	<b>258,722,341.05</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>90,546,441.71</b>	<b>192,113,325.39</b>
210101	Үндсэн цалин	55,971,399.84	90,421,889.83
210102	Нэмэгдэл	23,018,271.89	76,051,414.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,085,000.00	2,507,500.00
210104	Урамшуулал	9,471,769.98	23,132,521.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>11,454,030.19</b>	<b>23,902,462.93</b>
210201	Тэтгэврийн даатгал	7,733,740.52	16,376,074.81
210202	Тэтгэмжийн даатгал	971,322.42	1,836,597.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	733,057.92	918,298.53
210204	Ажилгүйдлийн даатгал	183,264.50	918,298.53
210205	Эрүүл мэндийн даатгал	1,832,644.83	3,853,194.04
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,550,254.17</b>	<b>9,437,978.72</b>
210401	Бичиг хэрэг	4,518,276.86	2,373,100.00
210402	Тээвэр, шатахуун	5,008,579.40	4,767,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,537,997.91	1,616,578.72
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	485,400.00	680,900.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,966,400.00</b>	<b>4,279,600.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		120,000.00



210602	Тавилга	20,000.00	-
210604	Урсгал засвар	2,946,400.00	4,159,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,432,000.00</b>	<b>1,762,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,432,000.00	1,762,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,868,137.00</b>	<b>11,869,837.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,671,000.00	11,165,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	650,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	37,737.00	54,837.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,498,832.83</b>	<b>15,357,137.01</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,455,000.00	5,299,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,150,000.00	2,696,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,893,832.83	7,361,237.01
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>14,164,736.93</b>	<b>41,484,635.96</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>12,828,000.00</b>	<b>35,423,384.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	12,828,000.00	35,423,384.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,239,000.00</b>	<b>3,590,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,239,000.00	3,590,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>97,736.93</b>	<b>2,471,251.96</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	97,736.93	2,471,251.96
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>(1,670,532.83)</b>	<b>11,490,102.99</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>1,673,277.68</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,673,277.68
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	<b>-</b>	<b>(1,673,277.68)</b>
<b>V</b>	<b>НИЙТ ҮР ДҮН</b>	<b>(1,670,532.83)</b>	<b>9,816,825.31</b>



## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/Төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>145,810,300.00</b>	<b>308,697,200.00</b>	
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>145,810,300.00</b>	<b>308,697,200.00</b>	
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>9,500,000.00</b>	<b>12,000,000.00</b>	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,500,000.00	12,000,000.00	
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>136,310,300.00</b>	<b>296,697,200.00</b>	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	136,310,300.00	296,697,200.00	
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>140,845,500.00</b>	<b>296,520,700.00</b>	
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>140,845,500.00</b>	<b>296,520,700.00</b>	
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>126,032,763.07</b>	<b>255,036,064.04</b>	
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>90,532,241.71</b>	<b>192,113,325.39</b>	
210101	Үндсэн цалин	54,003,389.42	90,421,889.83	
210102	Нэмэгдэл	22,542,407.01	76,051,414.56	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,085,000.00	2,507,500.00	
210104	Урамшуулал	11,901,445.28	23,132,521.00	
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>11,454,030.19</b>	<b>23,902,462.93</b>	
210201	Тэтгэврийн даатгал	7,728,240.52	16,376,074.81	
210202	Тэтгэмжийн даатгал	976,822.42	1,836,597.02	
210203	ҮОМШӨ-ний даатгал	733,057.92	918,298.53	
210204	Ажилгүйдлийн даатгал	183,264.50	918,298.53	
210205	Эрүүл мэндийн даатгал	1,832,644.83	3,853,194.04	
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,330,254.17</b>	<b>10,521,038.72</b>	
210401	Бичиг хэрэг	2,350,276.86	3,104,100.00	
210402	Тээвэр, шатахуун	5,008,579.40	4,767,400.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,537,997.91	1,616,578.72	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	433,400.00	1,032,960.00	
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,966,400.00</b>	<b>4,279,600.00</b>	
210601	<b>Багаж, техник хэрэгсэл</b>	-	<b>120,000.00</b>	
210602	Тавилга	20,000.00	-	
210604	Урсгал засвар	2,946,400.00	4,159,600.00	
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,432,000.00</b>	<b>1,762,000.00</b>	
210702	Дотоод албан томилолт	1,432,000.00	1,762,000.00	
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,078,137.00</b>	<b>14,461,737.00</b>	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,331,000.00	13,756,900.00	


210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	650,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	59,400.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	37,737.00	54,837.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,239,700.00</b>	<b>7,995,900.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,913,700.00	5,299,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,326,000.00	2,696,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>14,812,736.93</b>	<b>41,484,635.96</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>13,476,000.00</b>	<b>35,423,384.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	13,476,000.00	<b>35,423,384.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,239,000.00</b>	<b>3,590,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,239,000.00	3,590,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>97,736.93</b>	<b>2,471,251.96</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	97,736.93	<b>2,471,251.96</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>4,964,800.00</b>	<b>12,176,500.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,964,800.00</b>	<b>12,176,500.00</b>
	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>4,964,800.00</b>	<b>12,176,500.00</b>
222001	Тоног төхөөрөмж	2,819,000.00	<b>10,379,500.00</b>
223001	Бусад хөрөнгө	2,145,800.00	1,797,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(4,964,800.00)</b>	<b>(12,176,500.00)</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-



## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>8,735,000.00</b>	<b>56,447.44</b>	<b>33,458,873.01</b>	<b>42,250,320.45</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,670,532.83)	<b>(1,670,532.83)</b>
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>8,735,000.00</b>	<b>56,447.44</b>	<b>31,788,340.18</b>	<b>40,579,787.62</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	9,816,825.31	9,816,825.31
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>8,735,000.00</b>	<b>56,447.44</b>	<b>41,605,165.49</b>	<b>50,396,612.93</b>




## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-	-	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>308,441,200.00</b>	<b>294,225,948.04</b>	<b>(14,215,251.96)</b>	<b>95.39</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>308,441,200.00</b>	<b>294,225,948.04</b>	<b>(14,215,251.96)</b>	<b>95.39</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>272,091,200.00</b>	<b>258,502,564.04</b>	<b>(13,588,635.96)</b>	<b>95.01</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>202,899,500.00</b>	<b>192,113,325.39</b>	<b>(10,786,174.61)</b>	<b>94.68</b>
210101	Үндсэн цалин	86,721,900.00	90,421,889.83	3,699,989.83	104.27
210102	Нэмэгдэл	88,571,400.00	76,051,414.56	(12,519,985.44)	85.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,465,000.00	2,507,500.00	(957,500.00)	72.37
210104	Урамшуулал	24,141,200.00	23,132,521.00	(1,008,679.00)	95.82
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>25,362,500.00</b>	<b>23,902,462.93</b>	<b>(1,460,037.07)</b>	<b>94.24</b>
210201	Тэтгэврийн даатгал	17,246,500.00	16,376,074.81	(870,425.19)	94.95
210202	Тэтгэмжийн даатгал	2,029,000.00	1,836,597.02	(192,402.98)	90.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,014,500.00	918,298.53	(96,201.47)	90.52
210204	Ажилгүйдлийн даатгал	1,014,500.00	918,298.53	(96,201.47)	90.52
210205	Эрүүл мэндийн даатгал	4,058,000.00	3,853,194.04	(204,805.96)	94.95
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,113,200.00</b>	<b>7,429,038.72</b>	<b>(684,161.28)</b>	<b>91.57</b>
210401	Бичиг хэрэг	2,640,000.00	2,639,500.00	(500.00)	99.98
210402	Тээвэр, шатахуун	3,600,000.00	3,600,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	989,200.00	306,578.72	(682,621.28)	30.99
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	884,000.00	882,960.00	(1,040.00)	99.88
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>16,460,000.00</b>	<b>16,456,100.00</b>	<b>(3,900.00)</b>	<b>99.98</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,500,000.00	10,499,500.00	(500.00)	100.00
210602	Тавилга	1,800,000.00	1,797,000.00	(3,000.00)	99.83
210604	Урсгал засвар	4,160,000.00	4,159,600.00	(400.00)	99.99
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,800,000.00</b>	<b>1,762,000.00</b>	<b>(38,000.00)</b>	<b>97.89</b>
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	1,762,000.00	(38,000.00)	97.89
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,656,000.00</b>	<b>9,043,797.00</b>	<b>(612,263.00)</b>	<b>93.66</b>



210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,685,500.00	8,338,900.00	(346,600.00)	96.01
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	750,000.00	650,000.00	(100,000.00)	86.67
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	-	(100,000.00)	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98,500.00	54,837.00	(43,663.00)	55.67
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-	(22,000.00)	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,800,000.00</b>	<b>7,795,900.00</b>	<b>(4,100.00)</b>	<b>99.95</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,300,000.00	5,299,300.00	(700.00)	99.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,000.00	2,496,600.00	(3,400.00)	99.86
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>36,350,000.00</b>	<b>35,723,384.00</b>	<b>(626,616.00)</b>	<b>98.28</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>36,000,000.00</b>	<b>35,423,384.00</b>	<b>(576,616.00)</b>	<b>98.40</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	36,000,000.00	35,423,384.00	(576,616.00)	98.40
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>350,000.00</b>	<b>300,000.00</b>	<b>(50,000.00)</b>	<b>85.71</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	350,000.00	300,000.00	(50,000.00)	85.71
<b>1</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>308,441,200.00</b>	<b>294,225,948.04</b>	<b>(14,215,251.96)</b>	<b>95.39</b>
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	308,441,200.00	294,225,948.04	(14,215,251.96)	95.39
132001	Орон нутгийн төсвөөс	308,441,200.00	294,225,948.04	(14,215,251.96)	95.39
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.00
3	Төсвийн байгууллага	1	1	-	100.00
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	5	5	-	100.00
6	Удирдах ажилтан	1	1	-	100.00
7	Гүйцэтгэх ажилтан	4	4	-	100.00
8	Үйлчлэх ажилтан			-	100.00
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	5	5	-	100.00
25	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	3	3	-	100.00
27	Төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮ)	1	1	-	100.00
35	Улс төрийн албан хаагч (УТ)	1	1	-	100.00



## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	12,000,000.00	(12,000,000.00)
УРСГАЛ ЗАРДАЛ	-	12,000,000.00	(12,000,000.00)
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>8,710,000.00</b>	<b>(8,710,000.00)</b>
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	<b>3,092,000.00</b>	<b>(3,092,000.00)</b>
Бичиг хэрэг	-	464,600.00	(464,600.00)
Тээвэр, шатахуун	-	1,167,400.00	(1,167,400.00)
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,310,000.00	(1,310,000.00)
Бага, үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	-	150,000.00	(150,000.00)
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	<b>5,418,000.00</b>	<b>(5,418,000.00)</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	5,418,000.00	(5,418,000.00)
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>200,000.00</b>	<b>(200,000.00)</b>
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	200,000.00	(200,000.00)
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>3,290,000.00</b>	<b>(3,290,000.00)</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	<b>3,290,000.00</b>	<b>(3,290,000.00)</b>
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,290,000.00	(3,290,000.00)
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>12,000,000.00</b>	<b>(12,000,000.00)</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>12,000,000.00</b>	<b>(12,000,000.00)</b>
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	12,000,000.00	(12,000,000.00)
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-	-
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-	-
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-	-

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

## 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь “Монгол Улсын хуулийг дээдлэн сахиж иргэдийнхээ эрх ашиг, сонирхлыг хамгаалан, Нутгийн өөрөө удирдах байгууллагын ажлын үр нөлөө, чанар, хүртээмжийг дээшлүүлснээр нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж, орон нутгаа хөгжүүлэхэд чиглэнэ.” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа
- Сумын нийгэм эдийн засаг, хот байгуулалтыг хөгжүүлэх богино хугацааны бодлогыг тодорхойлох.
- Суманд үйл ажиллагаа эрхэлж буй хоршоо, жижиг дунд бизнесийг дэмжих.
- Нутгийн өөрөө удирдах ёсыг хөгжүүлэх, чадавхыг нь дээшлүүлж бие даан ажиллах эрх зүйн орчныг хэвшүүлэх.
- Иргэд болон хамт олны бүтээлч санаачилга, идэвхтэй оролцоонд тулгуурлан ажиллах зарчмыг баримтлах.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Монгол улсын үндсэн хуулийн 59 дүгээр зүйл: Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг нийслэл, сум дүүрэгт, тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороод иргэдийн Нийтийн Хурал байна. Аймаг нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй. Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны тогтоол 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 12 дугаар тогтоол “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн байна.
- Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 238 дугаар тогтоол “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн.
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 82 дугаар тогтоол “Орон нутгийн нэмэгдэлд өөрчлөлт оруулах тухай”. 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн.
- Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/52 “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн.
- Монгол улсын сангийн сайдын 211 дүгээр тушаал “Эдийн засгийн ангилал шинэчлэн батлах тухай” 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн.
- Шинэчлэн найруулсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй гэж үзэж* байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал байна гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон 2020 онд боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,816.8 мянган төгрөгөөр бууу 24.2 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
“Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	4,963.8	8,638.8	3,675.0
Үндсэн хөрөнгө	35,616.0	41,757.9	6,141.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>40,579.8</b>	<b>50,396.6</b>	<b>9,816.8</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,735.0	8,735.0	-
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>40,579.8</b>	<b>50,396.6</b>	<b>9,816.8</b>

Мөнгөн хөрөнгийн дансанд үлдэгдэлгүй гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл нь 8,638.8 мянган төгрөг болж 3,675.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 31,018.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаанд 27,343.9 мянган төгрөгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 41,757.9 мянган төгрөг болж 6,141.9 мянган төгрөгөөр өссөн нь тухайн онд төсвийн хөрөнгөөр машин тоног төхөөрөмжийн дансанд 10,379.5 мянган төгрөг, тавилга эд хогшлын дансанд 1,797.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан.

Машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй 3,749.9 мянган төгрөгийн 2 хөрөнгийг данснаас хасаж, 2,999.8 мянган төгрөгөөр Дархан-Уул аймгийн Орон Нутгийн Өмчийн Газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/16 тоот тушаалаар дахин үнэлж бүртгэсэн.

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2024 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 01/А-313 тоот тушаалаар машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй 2,966.4 мянган төгрөгийн үнэ бүхий 4 хөрөнгө, тавилга эд хогшлын дансанд бүртгэлтэй 1,268.2 төгрөгийн үнэ бүхий 7 хөрөнгийг акталсан.

Мөн машин тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй 2,499.0 төгрөгийн үнэ бүхий 8 хөрөнгийг Дархан-Уул аймгийн Орон Нутгийн Өмчийн Газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/18 тоот тушаалаар Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Цагдаагийн хэлтэст шилжүүлсэн ба тайлант онд 7,361.2 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 287,441.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 287,441.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант оны төсвийг 287,441.2 мянган төгрөгөөр баталсан ба жилийн эцэст 21,000.0 мянган төгрөгөөр тодотгол оруулж зардлыг нэмэгдүүлж баталсан.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 308,441.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 296,697.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 294,225.9 мянган төгрөг буюу 95.39 хувьтай байгаа нь цалингийн сангаас 10,786.2 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 1,460.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлаас 684.2 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлаас 3.9 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардлаас 38.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 612,3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 4.1 мянган төгрөг, урсгал шилжүүлгээс 626.6 мянган төгрөгийг тус тус хэмнэж, 2,471.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2 Хөтөлбөр арга, хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

	д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
					Зөрүү	Биелэлт
70105	1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	250,260.2	237,185.30	13,074.9	94.77
	2	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	4,160.0	4,159.6	0.4	99.99
	3	80205-Мэдээлэл сурталчилгааны зардал	1,683.5	1,350.0	333.5	80.19
	4	80802-Ажил олгогчдоос олгох тэтгэмж	350.0	300.0	50.0	85.71
	5	80825- БИНХ даргын урамшуулал	15,187.5	15,007.6	179.9	98.81
	6	81505-ИТХ суудалтай намуудад олгох	36,000.0	35,423.4	576.6	98.39
	7	81549-Ахмадын сан	800.0	800.0	-	100.00
		<b>Дүн</b>	<b>308,441.2</b>	<b>294,225.9</b>	<b>14,215.3</b>	<b>95,39</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Шарын гол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллага нь нийт 5 ажилтантай үүнээс Улс төрийн 1 албан хаагч, Төрийн захиргааны 3 албан хаагч, Төрийн үйлчилгээний 1 албан хаагчтай үйл ажиллагаагаа явуулж байна. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 20,229.2 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны 14 хөтөлбөр боловсруулж төлөвлөсөн. Зөвлөх үйлчилгээ 1,959.7 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээ 18,269.5 мянган төгрөгийн шууд худалдан авалтын гэрээ байгуулан ажилласан. Тайлант онд Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 8,339.9 мянган төгрөгийн Түүхэн товчоо номны хэвлэл, тайлангийн хэвлэлийн зардлууд, Бараа ажил үйлчилгээний зардалаас 5,299.0 мянган төгрөгийн хуралдааны цай хоолны зардал, ахмадын сангийн зардлууд тус тус гарсан байна.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 12,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна. Үүнээс: 464.6 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд, 1,167.4 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардалд, 1,310.0 мянган төгрөгийг шуудан холбооны зардалд, 150.0 мянган төгрөгийг бага үнэтэй, түргэн элэгдэх зардалд 5,418.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд, 200.0 мянган төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардалд, 3,290.0 мянган төгрөгийг шагнал урамшуулалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөрийн арга хэмжээ хэрэгжээгүй байна.

### **3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд 20,229.2 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны 14 хөтөлбөр боловсруулж төлөвлөсөн. Хичээл үйлдвэрлэлийн зардалд 2,500.0 мянган төгрөг, Мэдээлэл технологийн зардалд 1,683.5 мянган төгрөг, Бараа үйлчилгээний бусад зардалд 2,500.0 мянган төгрөг, Бичиг хэргийн зардалд 1,800.0 мянган төгрөг, Урсгал засварын зардалд 800.0 мянган төгрөг, Аудит баталгаажуулалтын зардалд 750.0 мянган төгрөг, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 1,502.0 мянган төгрөг, Тээврийн хэрэгсэлийн татвар 98.5 мянган төгрөг. Оношлогоо 22.0 мянган төгрөг, Даатгалын үйлчилгээнд 100.0 мянган төгрөг, Бага үнэтэй, түргэн элэгдэх зардалд 884.0 мянган төгрөг, Шатахууны зардалд 3,600.0, Багаж техник хэрэгсэлийн зардалд 3,000.0 мянган төгрөг, Шуудан холбоо, интернетийн зардалд 989.2 мянган төгрөгийг шууд худалдан авалтаар тус тус зарцуулсан.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Шарын гол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах тайлантай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит” ХХК-ийн аудитор Б.Хоролбат гүйцэтгэж, Анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Магсаржалам, гүйцэтгэх захирал С.Оргил нар дараагийн шатны чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит” ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02/06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлан дахь нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 152,445.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 3,048.9 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэхгүй байх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн холбоотой алдаа, зөрчил илрээгүй болно.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамааруулан шалгалаа.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2024 онд мэдээлбэл зохих 171 мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн байршуулсан байгаа тул шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа, зөрчилтэй асуудал байхгүй.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөрчил, санхүүгийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй 1 зөрчил илэрсэн тул цаашид үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах 2 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилтийг шалгахад 100 хувь хэрэгжсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	88,494.0	2	88,494.0	100.0

/мянган төгрөгөөр/

Нийт дүн	2	88,494.0	2	88,494.0	100.0
----------	---	----------	---	----------	-------

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,098.3 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 3,077.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,021.0 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Үүнд:

1. Үндсэн цалингийн 210101 дансанд 77.4 мянган төгрөг дутуу, тэтгэвэрийн даатгалын 210201 дансанд 77.4 мянган төгрөгөөр илүү буюу хооронд нь гүйлгэн бүртгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", санхүүгийн тайлангийн "Ангилал", "Нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн үр дүнгийн тайланд 210201 дансанд илүү бүртгэсэн 77.4 мянган төгрөгийг 210101 дансанд бүртгэж залруулсан.
2. Дахин үнэлсэн 2,999.9 мянган төгрөгийн 2 хөрөнгийг бусад хөрөнгө буюу 120009 дансанд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-ын 3.4 дэх хэсэг, санхүүгийн тайлангийн аудитын "Ангилал", "Нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй орлого буюу 1200045 дансанд бүртгэж залруулсан.

Мөн аудитаар нийт 3,021.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэн тул цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах 2 зөвлөмж өгсөн.

##### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

##### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

##### 5.3 Зөвлөмж

##### 5.3.1. Бараа материал данстай холбоотой асуудал

###### 5.3.1.1 Илрүүлэлт:

Автомашинны шатахуун зарцуулалтын норм тогтоогоогүй, жолоочийн тооцоог бодоогүй, зардлыг тооцооллын дагуу бодитоор зардалд тусгаж баталгаажуулаагүй 3021.0 мянган төгрөг тайлагнасан байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зардал хооронд гүйлгэн зарцуулсан	1	77.4			1	77.4	1	77.4				
Орлого буруу бүртгэсэн	1	2,999.9			1	2,999.9	1	2,999.9				
Дүн	2	3,077.3			2	3,077.3	2	3,077.3				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шатахууны тооцоо бодоогүй	1	3021.0					1	3021.0				
Дүн	1	3021.0					1	3021.0				

Тайлант онд батлагдсан төсвөөс ахмадын сан байгуулж, хөрөнгө мөнгө төвлөрүүлээгүй байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах", Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын 1.1, 1.2, 1.3, 2.1.1 дэх заалтуудтай нийцэхгүй байна.

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Ахмадын сан байгуулж, хөрөнгө мөнгө төвлөрүүлээгүй	1	-						1	
Дүн	1							1	

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.